



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

БАТЛАВ.
САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ
/Албан тушаал/



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УДИРДАМЖ

2024 оны 02 дугаар сарын 06

дугаар 12/16

ТӨЛӨВЛӨГӨӨТ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ТУХАЙ

Б.УУГАНБАЯР
Гарын үсгийн тайлал/

О.Доржсүрэн

Хяналт шалгалтын
дохион байгууллагын

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл


Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5³.1 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 6.1 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан Стандарт, хэмжил зүйн салбарын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө"-г үндэслэн Монгол Улсын зах зээлд худалдаалагдаж буй массын хэмжлийн хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдалд Хэмжил зүйн тухай хууль болон холбогдох стандартын дагуу улсын хэмжээнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхэд хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг массын хэмжлийн хэмжих хэрэгслийг импортлох, бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллага болон бусад аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн худалдан борлуулж буй жингүүдийн загварын туршилт, баталгаажуулалтын байдалд үзлэг шалгалт хийх, баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгах, тайлбар мэдээлэл авах, илэрсэн зөрчлийг дүрс бичлэг, фото зургаар баримтжуулах, зөрчлийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг арга хэлбэрээр хийж гүйцэтгэнэ.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн объектын нэр



Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийслэл болон 21 аймагт массын хэмжлийн хэмжих хэрэгслийг импортлох, худалдах үйл ажиллагааг эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хамруулна.

Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг дараах чиглэлээр хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Массын хэмжлийн хэмжих хэрэгслийг импортлон, худалдаж буй аж ахуйн нэгж байгууллага нь чадавхia үнэлүүлж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн эсэх;
2. Массын хэмжлийн хэмжих хэрэгслийн загварыг батлуулж, Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн хэмжих хэрэгслийн хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлсэн эсэх;
3. Массын хэмжлийн хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулсан эсэхийг тус тус шалгаж Хэмжил зүйн тухай хууль, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд улсын байцаагчийн бүрэн эрхийн хурээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зөрчлийг таслан зогсоно.

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч

Шалгалтыг Стандарт, хэмжил зүйн газар болон 21 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Хэмжил зүйн хяналтын улсын /ахлах/ байцаагчид хийж гүйцэтгэнэ.

Тав. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл

Массын хэмжлийн хэмжих хэрэгслийг импортлох, худалдах үйл ажиллагааны хэмжлийн нэгдмэл байдалд өмнө нь хяналт шалгалт хийгдэж байгаагүй.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, иргэдэд танилцуулж, улсын байцаагчийн холбогдох шийдвэрийг хүргүүлнэ.

Засгийн газрын 2022 оны "Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай" 479 дүгээр тогтоолын 12 дугаар зүйлийн 12.6, 12.7 дахь заалтын дагуу хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн объект бүрийн мэдээллийг хяналт шалгалтын цахим системд бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хэмжил зүйн хяналтын улсын байцаагчид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын танилцуулга болон хавсралт хүснэгтийн дагуу гаргасан судалгааг 2024 оны 06 дугаар сарын 21, 11 дүгээр сарын 21-ний өдрийн дотор тус тус албан бичгээр болон цахим хаяг

/Baasan@masm.gov.mn/-аар Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн бодлогын газарт ирүүлнэ.

Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, шалгалтын танилцуулга, улсын байцаагчийн эрх зүйн бусад акт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж салбарын улсын ерөнхий байцаагчид танилцуулан, гарсан шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 06 -ны өдрийн 12:16 тоот удирдамжийн хавсралт



МАССЫН ХЭМЖЛИЙН ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙГ ИМПОРТЛОХ, ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ
АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭД ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРТГЭЛ

2024 оны дугаар сарын -ны өдөр